



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТУГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 05 сарын 06 өдөр

Дугаар A/40

Улаанбаатар хот

Г

Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт
өөрчлөлт оруулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн A/141 тоот тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-д дараах өөрчлөлтүүдийг оруулсугай. Үүнд:

"Хөдөлмөрийн дотоод журам"-ын 4.1.1-д "Долоо хоногийн ажлын цаг нь 40, ердийн ажлын өдрийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна. Ажлын цаг өглөө / 08⁰⁰ цагт эхэлж, орой 17⁰⁰ цагт дуусна /-гэснийг "8³⁰ цагт эхэлж, орой 17³⁰ цагт дуусна" гэж, 4.1.2-д үдийн амралтын цаг 12⁰⁰-13⁰⁰ цагийн хооронд байна" гэснийг "12³⁰-13³⁰ цагийн хооронд байна" гэж, 4.3.4-д "шинээр ажилд орсон ажилтанд 9 сар тасралтгүй ажилласны дараа ээлжийн амралт эдлэх эрх үүснэ" гэснийг "шинээр ажилд орсон ажилтанд 11 сар тасралтгүй ажилласны дараа ээлжийн амралт эдлэх эрх үүснэ" гэж тус тус өөрчилсүгэй.


2. 4.1.1-д "Зам талбайн үйлчлэгч нарын "ажлын цаг нь өвлийн улиралд 07³⁰-17³⁰ хооронд, зуны улиралд 07⁰⁰-17⁰⁰ хооронд байх бөгөөд үдийн амралт 2 цаг байна" гэж нэмсүгэй.

3. 11.2.11-д "Хөдөлмөрийн гэрээ нь ажил олгогчийн санаачлагаар цуцлагдсан иргэнийг 1 жилийн хугацаанд эргэж ажилд авахгүй" гэснийг хассугай.

4. Хөдөлмөрийн дотоод журамд оруулсан өөрчлөлтүүдийг бүх ажилтнуудад танилцуулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга /Б.Мөнх-Оргил/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.ЭНХСАЙХАН



TT38526 № 8115125

2130300079